

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2018.02.06

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны төлөвлөгөөнд 6 бүлгийн хүрээнд 198 заалтыг хэрэгжүүлэхээр тусган ажилласан байна. Үүнийг бүлгээр нь харуулбал:

Засаглалын хүрээнд – 39 заалт

Эдийн засгийн хүрээнд- 13 заалт

Нийгмийн бодлогын хүрээнд- 56 заалт

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хүрээнд- 26

Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн хүрээнд – 22


Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээнд – 42 заалт тус тус хяналтанд хэрэгжиж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн 89-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу үнэлж үзэхэд 198 заалтын биелэлт 92,71 хувьтай хэрэгжиж байна.


Сүүлийн хагас жилд бүх хэлтэс агентлагт явцын үнэлгээ хийж цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгч ажиллахаас гадна ЗГ-ын 2017 оны 89 дүгээр журамд хэрхэн тусгагдсан талаар сургалтыг хэлтсүүдийн ХШҮ хариуцсан мэргэжилтнүүд болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаар явж хийсэн. Ингэснээр тухайн байгууллагад холбогдолтой заалтуудыг бүрэн хяналтад авч, 2017 оны 89 дүгээр журмыг мөрдөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар санаачлага гарган ажиллаж байна. 2018 онд явцын хяналт шинжилгээг тасралтгүй хийхээр төлөвлөж байна.

Хэрэгжилтийг графикаар харуулбал:

198 заалтын хэрэгжилт 92,71 хувь



6 бүлгийн хэрэгжилтийг графикаар харуулбал:




Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад эхний 8 сарын байдлаар үнэлгээ хийхэд 71,4 хувийн биелэлттэй хэрэгжиж байсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 9,10, 11 саруудад төлөвлөсөн арга хэмжээ нь удаашралтай хэрэгжиж байгаа хэлтэс агентлагуудаар явцын хяналт шинжилгээг хийж, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгч, 9, 11 сард аймгийн засаг даргын “Сонсгол мэдээллийн” үйл ажиллагааг зохион байгуулж “Ажил эрчимжүүлэх” албан тоотоор хэлтэс агентлагуудад үүрэг чиглэл өгч ажилласан. Ингэснээр Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт эхний хагас жилээс 21,31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛТСҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ**

№	Хэлтэс	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь					Дундаж хувь
			100	70	40	0	ҮБ	
1	ТЗУХ түүний харьяа агентлагууд	19	17	1	-	-	1	98,33
2	Нийгмийн бодлогын хэлтэс түүний харьяа агентлагууд	70	51	9	-	-	10	95,5
3	ХОХБТХэлтэс түүний харьяа агентлагууд	84	53	15	6	-	10	89,05
4	ХЭЗХэлтэс түүний харьяа агентлагууд	19	15	4	-	-	-	93,68
5	СТСХэлтэс түүний харьяа агентлагууд	6	4	2	-	-	-	90
Дундаж		198	140	31	6	-	21	92,71

2017 оны төлөвлөлт, гүйцэтгэлээс харахад тухайн арга хэмжээний төсөв нь ОНХС-гийн жагсаалтад багтсан эсэх, Улсын төсвөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн тохиолдолд санал дэмжигдсэн эсэх нь тодорхой бус, мөн төлөвлөсөн арга хэмжээ нь улсын болон орон нутгийн төсөвт тусгагдаагүй эсвэл ямар нэгэн шалтгаанаар төсөв нь хасагдсан, дээд газраас нь шалтгаалсны улмаас тухайн арга хэмжээний хэрэгжилт үнэлэх боломжгүй болон удаашрахад нөлөөлж байна.

Үнэлэх боломжгүй байгаа 21 арга хэмжээг хэлтсээр нь харуулбал:



Хэрэгжилт удаашралтай буюу 40%-тай заалтууд:

№	Арга хэмжээ	Шалгуур	Хариуцах байгууллага	Хэрэгжилт
1	4.1.10 ХАА-н биржийн үйл ажиллагааг тогтмол явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, биржийн арилжааг орон нутагтаа хөгжүүлнэ.	ХАА-н биржийн үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	ХХААГ	Аймгийн ХААХоршоологчдын холбоо, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран 15 сумын 60 гаруй түүхий эд бэлтгэн нийлүүлэгч хоршоо, ААНэгжүүдийн төлөөлөлд “Биржийн арилжаанд хэрхэн оролцох талаарх” сургалтыг зохион байгуулж мэдлэг мэдээллийг олгосон.
2	4.1.14 Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөжүүлж, аймгийн тэжээлийн үрийн хэрэгцээг хангана.	Малын тэжээлийн ургамал тариалах талбайг өмнөх оныхоос 5 га-аар, хураан авах ургацын хэмжээг 10 тн-оор тус тус нэмэгдүүлэх	ХХААГ	Хулд суманд иргэн Т.Төмөрчулуун 0,5 га талбайд тэжээлийн ургамал тариалж байна. Аймгийн хэмжээнд нийт 30,5 га талбайд малын тэжээлийн ургамлын тариалсан хэдий ч урьд оноос тариалсан талбай 0,5 га-р нэмэгдсэн хэдий ч усны нөхцөл байдлаас шалтгаалан 30 га талбайд ургац алдаж 2017 онд нийт 3.5 тн ургац хураан авсан.
3	6.1.5 Хэвтээ тэнхлэгийн замыг барих ажлыг шийдвэрлүүлэх замаар Онгийн голын гүүрний ажлыг эхлүүлнэ.	Зураг төсвийг хүлээн авах,	ХОХБТХ	Зургийн даалгавар боловсруулсан.
4	6.1.11 Сумдын ерөнхий төлөвлөгөөтэй болгох асуудлыг шийдвэрлэнэ.	6 сумдын ерөнхий төлөвлөгөөг үргэлжлүүлэн хийлгэх ажлын гэрээ байгуулах, мөн 4 сумдын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авах	ХОХБТХ	Баянжаргалан, Хулд, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Сайхан-Овоо, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумдуудыг сум хөгжүүлэх сангийн хөрөнгөндөө тусгуулах чиглэл өгөөд байна. Одоогоор Баянжаргалан, Дэрэн, Дэлгэрцогт, Адаацаг, Сайхан-Овоо сумдууд хөрөнгийн асуудлаа тодорхой хэмжээнд шийдвэрлээд байна. Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах компанийг судалж байна.
5	Дэлгэрхангай сумын 15 ортой эмнэлгийн барилга барих	Ажлыг бүрэн дуусгах	ХОХБТХ	Дэлгэрхангай сумын 15 ортой эмнэлгийн барилгын гүйцэтгэгчээр "ОГОСЦ" ХХК 899,443,354 төгрөгөөр гэрээ байгуулж суурийн 120 сая төгрөгийг шийдвэрлүүлэн ажлыг гүйцэтгэлээ. 2018 онд барилгын угсралтын ажил үргэлжлэн явагдана.
6	Хүүхдийн парк- МТ колонк хүртэлх явган хүний замын ажил	Ажлыг бүрэн дуусгах	ХОХБТХ	Замын сангийн хөрөнгөөр 142,466,147 төгрөгөөр “Мандал шилтгээн” ХХК 1,48км явган хүний замын ажлын гэрээ байгуулан ажиллаж байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛТЭС АГЕНТЛАГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

Арга хэмжээний тоо	Хэлтэс нэр	Агентлаг	Нийт арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн-100%	Үүнээс				Хувь
					70 %	40 %	0 %	Үнэлэх боломжгүй	
ХОХБТХ - 84	ХОХБТХ		35	18	6	4	-	7	85
		ГХБХБГ	5	4	-	-	-	1	100
		ОНӨГ	4	2	1	-	-	1	90
		БОАЖГ	17	15	2	-	-	-	96,4
		ХХААГ	23	14	6	2	-	1	86,3
ТЗУХ - 19	ТЗУХ		12	10	1	-	-	1	97,2
		ОБГазар	3	3	-	-	-	-	100
		МХГазар	1	1	-	-	-	-	100
		ЦШ	3	3	-	-	-	-	100
СТСХ - 6	СТСХ		3	3	-	-	-	-	100
		ТХэлтэс	3	1	2	-	-	-	80
НБХ - 70	НБХ		12	5	3	-	-	4	88,7
		ЭМНДХ	2	2	-	-	-	-	100
		ЭМГ	9	7	1	-	-	1	96,2
		ГБХЗХГ	5	4	-	-	-	1	100
		ХХҮГ	13	10	2	-	-	1	95
		БСУГ	20	16	3	-	-	1	95,2
		БТСГ	4	4	-	-	-	-	100
ХЭЗХ-19	ХЭЗХ		6	4	2	-	-	-	90
		Архивын тасаг	2	2	-	-	-	-	100
		ШШГГ	1	1	-	-	-	-	100
		ШША	1	-	1	-	-	-	70
		ЦГазар	5	4	1	-	-	-	94
		УБХ	4	4	-	-	-	-	100

Цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж

1. ЗДҮАХ-ийн тухайн жилийн төлөвлөгөөнд хэлтсийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд өөрт хамааралтай болон хариуцсан харъяа хэлтэс, агентлагт хамааралтай заалтуудын шалгуур үзүүлэлтийг тодорхой оновчтой болгоход анхаарч ажиллах
2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой байдлаар тайлагнаж хэвших

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС